



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 12 сарын 2 өдөр

Дугаар 544

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 1.6 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.2, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2020 онд барьж ашиглалтад оруулсан нийт 6,985,951,354.00 (зургаан тэрбум есөн зуун наян таван сая есөн зуун тавин нэгэн мянга гурван зуун тавин дөрвөн) төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу Усны газрын хөрөнгөд болон Увс, Хөвсгөл аймгийн орон нутгийн өмчид бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Ганболд, Усны газрын дарга Ш.Мягмар, Увс, Хөвсгөл аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх, хөрөнгө эзэмших орон нутгийн өмчит хуулийн этгээдийг тогтоох, бүртгэлд тусгах ажлыг холбогдох хууль тогтоомж журмын дагуу зохион байгуулах;


2.2. Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2022 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА  Д.НАРАНГЭРЭЛ

132001559

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн
..... дугаар тогтоолын хавсралт

ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын үнэ (төгрөг)
Увс аймгийн Орон нутгийн өмчийн газарт						
1	Хөв цөөрөм /Увс аймаг, Хяргас сум/	2020	ш	1	4,283,999,539.00	4,283,999,539.00
2	Гүний худаг /Увс аймаг, Завхан сум/	2020	ш	1	35,000,000.00	35,000,000.00
	Хэсгийн дүн			2	4,318,999,539.00	4,318,999,539.00
Хөвсгөл аймгийн Орон нутгийн өмчийн газарт						
3	Аялал жуулчлал, мэдээлэл сурталчилгааны Соёмбо цогцолборын дэд бүтэц, тохижилт /Хөвсгөл аймаг Мөрөн сум/	2020	ш	1	806,951,815.00	806,951,815.00
	Хэсгийн дүн			1	806,951,815.00	806,951,815.00
Усны газарт						
4	Усны техник эдийн засгийн үндэслэл, ТЭЗҮ /Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг/	2020	ш	1	1,860,000,000.00	1,860,000,000.00
	Хэсгийн дүн			1	1,860,000,000.00	1,860,000,000.00
						6,985,951,354.00
	НИЙТ ДҮН					(Зургаан тэрбум есөн зуун наян таван сая есөн зуун тавин нэгэн мянга гурван тавин дөрвөн төгрөг)